

БАТЛАВ.  
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ЗЭНДМАА

**ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ (ТЕЛЕВИЗ)-ЭЭР ТҮГЭЭЖ БАЙГАА  
ЭМ, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАР СУРТАЛЧИЛГААНД  
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Үндэслэл**

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар байгуулагдаж, эм зүйн салбарын нэгдсэн бодлого, төрийн үйлчилгээг нэг бүтцэд төлөвлөрүүлэн, хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хуулийн 6-р зүйлийн 6.2.8 дахь хэсэг “эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналт”, 27-р зүйлийн 27.2 дахь заалтын дагуу “эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг” хянаж байна.

Тус хуулийн 26-р зүйлийн 26.1-д “жороор олгох болон эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эмийн мэдээллийг зөвхөн эмнэлгийн мэргэжилтэнд өгнө”, 26.2-д “эмийн мэдээлэл нь эмийг оновчтой, зүй зохистой, үр дүнтэй хэрэглэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байна”, 26.3-д “эмийн тухай мэдээлэл нь үнэн, зөв, бодитой бөгөөд үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчээс хараат бус байна”, 27-р зүйлийн 27.1-д жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг мэргэжлийн хэвлэл болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно” гэж заасан. Мөн зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Олон нийтийн мэдээлэх хэрэглэсээр зөвхөн жоргүй олгох эмийн тухай болон эмийг зохистой хэрэглэхтэй холбогдсон сурталчилгаа явуулж болно” гэж заасан байдаг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээж байгаа эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаанд тандалт үнэлгээ хийхэд 2021 онд 90.7%, 2022 онд 69.3% нь зөвшөөрөл аваагүй түгээсэн байна.

Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарим эмийг үр нөлөөг хэт дөвийлгөх, хэрэглэгчийг төөрөгдүүлэх, илэрч болох гаж нөлөөг орхигдуулж өрөөсгөл сурталчилж байгаа нь эмийн зохистой хэрэглээг алдагдуулж буй олон шалтгааны нэг болж байна. Иймд эмийн зар сурталчилгааны өнөөгийн байдалд тандалт үнэлгээ хийх шаардлагатай байна.

**Зорилго**

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээж байгаа эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны өнөөгийн байдалд тандалт үнэлгээг хийж, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах

### **Зорилт**

1. Зар сурталчилгааны холбогдох хууль, тогтоомжийн дагуу эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл авсан эсэхэд тандалт үнэлгээ хийх;
2. Олон улсын зар сурталчилгааны зөвшөөрөл олгох үйл ажиллагааг судлан, эрх зүйн орчныг сайжруулах
3. Нотолгоонд тулгуурласан мэдээллээр шийдвэр гаргагчидыг хангах

### **Хэрэгжүүлэгч байгууллага**

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

### **Санхүүжилт**

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага-7.100.000 төгрөг

### **Хамрах хүрээ**

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлэгийн болон арилжааны телевизүүд

### **Хугацаа**

2023 оны 03 сарын 01 - 2023 оны 03 сарын 31

### **Гүйцэтгэх ажлын хэсэг**

Ахлагч:	П.Цэцгээ (ЭЭХХЗГ-ЭАБТСГ-ын дарга)
Нарийн бичиг:	Э.Ундармаа (ЭЭХХЗГ-ЭАБТСГ-ын мэргэжилтэн)
Гишүүд:	Ч.Амаржаргал (ЭМЯ, ЭТТ-ийн ахлах шинжээч) Д.Өлзийдулам (ЭАБТСГ-ын мэргэжилтэн) Б.Уранбилэг (ЭАБТСГ-ын мэргэжилтэн)

### **Хүрэх үр дүн**

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл телевизээр сурталчилж байгаа эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний талаар нотолгоонд суурилсан мэдээлэлтэй болсон байна.

Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны эрх зүйн орчныг сайжруулахад шийдвэр гаргачдыг мэдээллээр хангасан байна

БАТЛАВ  
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭЖИЛТЭН Л.ЗЭНДМАА



**ЭМ, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ  
ҮНЭЛГЭЭГ ТОДОРХОЙЛОХ АЖЛЫН ТӨСӨВ**

№	Үйл ажиллагаа	Нэгж үнэ /₮/	Тоо хэмжээ /ш/	Нийт үнэ /₮/
1	Зар сурталчилгааны мэдээлэл цуглуулах	2,300,000	2 сар	4,600,000
2	Зар сурталчилгааны мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийх	21000	50	1,000,000 + 500,000
3	Тайлан боловсруулах, хянах,	30000	50	1,500,000
	<b>Нийт дүн</b>			<b>7,100,000</b>

7,100,000

БОЛОВСРУУЛСАН: *А.У.У.У.* УНДАРМАА (ЗАБТСГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН)

ХЯНАСАН: ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАНДАЛТ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА

П.ЦЭЦГЭЭ

САНХҮҮ, ТӨСВИЙН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

А.БОЛОР-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:  
ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

Д.ӨИЙДУЛАМ